

“Алтайн зам” ХК-ийн хувьцааг эзэмшихээр тендер саналын зарлахыг зөвшөөрөх тухай.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11, Компанийн тухай хуулийн 58.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1.”Алтайн зам” ХК-ийн нийт хувьцааны 88,02 хувь буюу 47661 ширхэгийг эзэмшдэг “Нью прогресс групп” ХХК-иас тус компанийн хувьцааны 11,98 хувь буюу 6492 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 115 төгрөгөөс доошгүй үнээр худалдан авч компанийн хувьцааг 100 хувь эзэмшихээр тендер санал гаргасныг зөвшөөрч, хүчинтэй байх хугацааг 2008 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.

2. Холбогдох хууль, журмын дагуу тендер саналаа нийтэд сурталчилж, хуулиар хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх, тендер саналын хугацаа дуусмагц ажлын 5 хоногт багтаан тендер саналын хэрэгжилтийн тайланг Хороонд ирүүлэхийг хувьцаа эзэмшигч “Нью прогресс групп” ХХК -д үүрэг болгосугай

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ /-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ